

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Төсвийн тухай хууль болон Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэх үүднээс нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Нийгмийн халамжийн газрыг нэгтгэх асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.		✓		
2.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвтэй нэгтгэх асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг тус боловсруулж Засгийн газрын газрын 2022.06.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.		✓		
3.	Нийгмийн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Монгол HD телевизтэй хамтран хийсэн 2 нэвтрүүлэг, 1 ярилцлага, 4 шторкийн агуулгыг хянан эцэслэв. Монгол HD телевизээр 6-р сарын 04, 11-нд “Халамжийн бодлого ба шинэчлэл” ярилцлага, 6-р сарын 05, 11-нд “Халамж” өнөөгийн нөхцөл байдал нэвтрүүлэг, 6-р сарын 18, 25-нд “Халамжийн шинэчлэл” нэвтрүүлгийг тус тус цацав.	✓			
4.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 тоот тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар ХНХ-ын дэд сайд С.Зулпхар, нарийн бичгийн даргаар БТГ-ын дарга А.Хишигбаяр болон төрийн байгууллага, ТББ, ОУ-ын байгууллага зэрэг нийт 10 гаруй байгууллагын төлөөллөөс бүрдсэн 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” тогтоолын төсөлд 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 01/1752 тоот албан бичгээр санал хүргүүлэв.			✓	
5.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын болон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудаас санал авч, эдгээр байгууллагуудын 50 гаруй төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, яамдын саналуудыг нэгтгэв. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 144 дүгээр зүйлийн 144.5 дахь хэсэгт заасныг үндэслэн “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн боллоо.		✓		
6.	“Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаалаар шинэчлэн, “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаалыг шинээр батлав.			✓	
7.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, танилцуулгын хамт санал авахаар яамдад Хөдөлмөр,			✓	

	нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01/1665 тоот албан бичгээр яам хүргүүлэв.				
8.	Монгол Улс “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах” тухай олон Улсын гэрээ конвенцид 1981 онд нэгдэн орсон. Засгийн газрын төлөөллийн бүрэлдэхүүн тус конвенцын ээлжит 10 дугаар тайлангийн хэрэгжилтийг НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах Хорооны 82 дугаар хуралдаанаар 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд хэлэлцүүлэн, амжилттай хамгааллаа.		√		
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
9.	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хэрэгжилтийн явцтай танилцах зорилгоор АХБ-ны зөвлөхүүдийн багтай 6 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд хамтран ажиллав. Уг төслийн хүрээнд нийслэлийн СХД, ЧД, БЗД-дэд хэрэгжүүлж эхэлж буй “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэгчээр “Монголын Улаан загалмайн нийгэмлэг” шалгарсантай холбогдуулан хөтөлбөрийг эхлүүлэх бэлтгэл арга хэмжээнүүдийн талаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав.			√	
10.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхижуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү үйлчилгээг “Төгсөлтийн аргачлал” загвараар туршин нэвтрүүлэхээр АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд Нийслэлийн ЗДТГ-тай хамтран 3 дүүрэгт 2022 оны 4 дүгээр сараас 2023 оны 12 дугаар сар хүртэл нийт 21 сарын хугацаанд хэрэгжүүлэх юм. Энэхүү туршилтын төслийн нэдсэн ажлын хэсгийг яам, агентлаг, дүүргийн түвшинд ХНХ-ын сайдын 2022 оны 6 дугаар сарын ...-ны өдрийн А/... тушаалаар байгууллаа. Уг тушаалаар ажлын хэсгийн ажиллах удирдамж зааврыг батлав. Туршилтын төсөлд хамрагдах 1520 өрхийг сонгох арга хэмжээг 6 дугаар сарын 30-ны өдрөөс Чингэлтэй дүүрэгт эхлүүлж байна			√	
11.	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-аас 2022 онд Монгол Улсад хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт шалгарсан “Зорилтот бүлгийн иргэдийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх” төслийн ерөнхий зураглал, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Японы талаас төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөөтэй танилцаж тодорхой саналуудыг өгч ажиллав. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан судалгааг хийж байгаа ба 2023 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байна			√	
12.	Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-оос улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэдээлийн технологийн 3 зөвлөхтэй гэрээ хийж, хэрхэн хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулж, хийх ажлын төлөвлөгөөнд санал өгөв. Мөн үндсэн болон олон улсын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, Азийн хөгжлийн банкинд хүргүүлэв.			√	
13.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголт, зарим үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж сайжруулах зорилгоор “Нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээний хэрэгжилтийг шалгах аян” зохион байгуулах тухай ХНХ-ын сайдын тушаалыг батлав. Аяныг тус яамны ХШҮДАГ болон МХЕГ-тай хамтран зохион байгуулна.			√	
14.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд “Нийгмийн халамжийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-ыг 21 аймгийн нийгмийн халамжийн мэргэжилтэн болон сумын нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийг оролцуулах сургалтыг зохион байгуулж байна. Үүнд: “Нийгмийн халамжийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-ыг Булган, Орхон, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Увс, Хэнтий, Дорнод, Сүхбаатаар аймгийн ХХҮГ-т зохион байгуулсан.			√	
15.	Хөдөлмөр Нийгмийн хамгааллын Сайдын 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Ахмад настны үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай” А/107 дугаар тушаалыг үндэслэн Бүтцийн өөрчлөлтийг зохион байгуулах талаар цахим хурал зохион байгуулав.			√	
16.	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, Ижоб платформыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,			√	

	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл зэрэг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан уулзалтыг 2022 оны 06 дугаар сарын 02,10,28-ны өдрүүдэд зохион байгуулав. Уулзалтаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хөтөлбөрүүдийн тайлан мэдээллийг хэрхэн боловсруулах талаар хэлэлцэж, маягтыг боловсруулав.				
17.	Аж ахуйн нэгж, байгууллагын 2022 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардлагатай гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг бий болгохоор "Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 339 дүгээр тогтоолыг хүчингүй болгох, тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулав.		√		
18.	"Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна. Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/124, А/126 дугаар тушаалуудаар нийт 79 аж ахуйн нэгж, байгууллагын 1565 гадаадын иргэний ажлын байрны төлбөрийг хөнгөлөв.			√	
19.	Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы санаачилгаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар "Хүүхдэд ээлтэй Монгол" хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганыг Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн гишүүд, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхдийн элч, эрдэмтэн, судлаачид, аж ахуй нэгж байгууллагын 650 гаруй төлөөллийг оролцуулан 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгууллаа. Чуулганы үр дүнд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцод заасан "Хүүхдийн дээд эрх ашгийг хангах" үндсэн зарчимд тулгуурлан Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т заасны дагуу "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлж ажиллах нэгдсэн зөвшилцөлд хүрч, зөвлөмж гаргасныг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01/1552 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн хүрээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4-т заасан шалгуур үзүүлэлт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/121 дүгээр тушаалаар байгуулж, шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулах ажлыг эхлүүллээ. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын "Төсөв төлөвлөх, хуваарилах аргачлал боловсруулж, хүүхдийн хөгжлийн үйлчилгээг санхүүжүүлэх зардлын норматив тогтоох ажлын удирдамж батлах тухай" 2022 оны А/120 тушаалыг батлуулж, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах чиглэлээр ирүүлсэн саналд хууль тогтоомжийн дагуу боловсруулах чиглэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01/1670 тоот албан бичгээр хүргүүлэв. -Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/12 дугаар тушаалаар байгуулагдсан Хүүхдийн төлөө сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн, сонгон шалгаруулж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгээс танилцуулсан санал дүгнэлтэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01/1704 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.			√	
20.	"Хорих ангиас суллагдаж буй залуучуудын бие даан амьдрах чадварыг дэмжих хөтөлбөр" эцэслэгдэж, 5 дугаар сарын 6-ны өдрийн 1/1258 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Тус салбарт харьяа агентлаг, байгууллагуудаар дахин хэлэлцэгдэж санал тусган эцэслэснээр ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах юм. ХНХ-ын сайдын тушаалаар батлах "Асрамж, халамжийн төвөөс насанд хүрч бие даан амьдрахаар гарч буй залуучуудыг дэмжих хөтөлбөр"-ийн төслийг асрамж, халамжийн төвүүд, аймаг, дүүргийн ЗХТ-ийн ажилтнуудад 2 удаа хэлэлцүүлж, саналыг тусган эцэслэв.			√	
21.	Тус яамнаас "Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил, үйлчилгээний талаар хэрэгжүүлж буй бодлого, арга зүй, "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон тэдний гэр бүлд үзүүлэх			√	

	нийгмийн ажлын арга зүй” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Завхан, Өвөрхангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Нэг цэгийн үйлчилгээний төв, сумдын Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудыг хамруулан 2022 оны 06 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Завхан аймагт 80 хүн, Өвөрхангай аймагт 84 хүн хамрагдав.				
22.	“Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г ЭМ-ийн болон ХНХ-ын сайдын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар батлуулав.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
23.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийг баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 230 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам”-ыг батлуулав.		√		
24.	2022 оны 5 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийн буцаан олголтод хамрагдах 276 523 даатгуулагчид 8 274 909 909 төгрөгийг 2022.06.27-оос олгож эхлэв.			√	
25.	Тэтгэвэр тогтооход баримтлах цалингийн итгэлцүүрийг шинэчлэн батлах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авав.			√	
26.	Тэтгэвэр тогтоолтын хуудас болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актыг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээс авч байх тухай Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/1747 тоот албан бичгээр хүргүүлэв.			√	
27.	Баруун бүсийн 8 аймгийн Нийгмийн даатгалын байцаагч (ажилтан) нарыг чадавхижуулах “Нийгмийн даатгалын эрх зүйн өөрчлөлт” сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 19-30-ны өдрүүдэд Увс, Завхан аймгуудад зохион байгуулсан. Бүсчилсэн сургалтад нийт 92 албан хаагч хамрагдав.			√	
28.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд “Нийгмийн халамжийн салбарын Олон нийтийн оролцонд түншэлсэн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-ыг 2022 оны 06 дугаар сарын 15-наас 16-ний өдрүүдэд ХНХЯамны 4 давхрын хурлын зааланд цахимар болон танхимаар 21 аймгийн ХХҮГ, хэлтсийн нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийг оролцуулсан сургалт зохион байгуулав.			√	
29.	Нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, халамжийн үйлчилгээний цахимжуулалт, төсвийн хэмнэлт, иргэдээс ирүүлж буй өргөдөл гомдол г.м. асуудлаар ХХҮЕГ, ННХГ, 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нартай цахим хурал зохион байгууллаа.			√	
30.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжүүлж байна. Төслийг 2022 оны 06 сарын 09-ний өдрөөс эхлүүлэн нийт 12 ээлжээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, ээлжийн хуваарь батлуулав. Төсөлд хамрагдах залуучуудын бүртгэлийн үйл ажиллагааг 2022 оны 05 сарын 16-26-ны өдрүүдэд www.e-mongolia.mn цахим системээр бүртгэн, сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Төслийн нэгдүгээр ээлж 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 238 оролцогчтойгоор Зэвсэгт хүчний 119 дүгээр анги дахь төслийн хотхонд үйл ажиллагаа эхэлсэн. Мөн төслийн хоёрдугаар ээлж 06 дугаар сарын 25-ны өдөр 308 оролцогчтойгоор эхэлж, нийт оролцогчдын профайлинг үнэлгээний нэгтгэлээс харахад ажилд шууд зуучлагдах боломжтой буюу хувиараа хөдөлмөр эрхлэх боломжтой иргэн 77, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд богино хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 116, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд урт хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 40, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх			√	

	<p>боломжгүй 6 оролцогч байна. Төсөлд оролцогчид өөрийгөө илэрхийлэх чадвар, өөртөө итгэх итгэл, хөдөлмөрийн сэдэл нэмэгдсэн байгаа нь профайлингийн ярилцлага хийх үед нийтлэг байдлаар ажиглагдсан нь төслийн эерэг үр дүн байв. 31 ажил олгогчийн 1473 ажлын байрыг танилцуулж, 152 оролцогч анкет бөглөж, 210 оролцогчийг ажлын ярилцлагад хамруулж, 73 оролцогч дадлагажих гэрээ байгуулсан бөгөөд мөн 7 аймгийн 322 ажил олгогчийн 991 ажлын байрыг танилцуулж, 56 оролцогчийг тухайн ажлын байруудад бүртгэсэн. Мөн оролцогч залуусын хувьд урт хугацааны ажилгүйдэлд өртсөн, ажилд ороход хүндрэлтэй иргэдийн төлөөлөл их байсан. Төсөлд хамрагдсан оролцогчдын хоорондын харилцаа, хандлага нэмэгдэж, нийгэмд эзлэх байр суурь, өөртөө итгэх итгэлтэй болж байна. Залуучуудад хувь хүний хөгжил, эх оронч үзэл, эрүүл, зөв амьдралын хэв маягийг эзэмших чадварыг сургалт, өдөр тутмын үйл ажиллагаагаар олгож байгаа нь сайшаалтай. Оролцогч залуучууд хамт олны дунд биеэ зөв авч явах, хүсэл мөрөөдөлдөө хэрхэн хүрэх, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж байгаа зэрэг эерэг үр дүн гарч байна. Төслийн 2-р ээлжийг 6 дугаар сарын 25-нд эхлэхээр бэлтгэл ажилдаа орсон байна. Төслийн 3-р ээлж 8 сарын 3-наас 16 хүртэл, 4, 5-р ээлж 8 сарын 20-ноос 9 сарын 2 хүртэл, 6, 7-р ээлж 9 сарын 5-наас 9 сарын 18 хүртэл, 8,9-р ээлж 9 сарын 21-нээс 10 сарын 4 хүртэл, 10,11-р ээлж 10 сарын 7-с 10 сарын 20 хүртэл хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажлын хэсэг бэлтгэл ханган ажиллаж байна.</p>				
31.	<p>Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үйлчлүүлэгчид чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ажил хайгч, ажилгүй иргэдийн хөдөлмөрлөх хэрэгцээг тодорхойлох үйлчилгээ буюу профайлингийн үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэн, 2022-2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд иргэдийг хамруулах ажилтай уялдуулан иргэдэд үнэлгээ хийхээр тусган Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Энэхүү үнэлгээний мэдээлэл дээр үндэслэн цаашид төрөөс иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үзүүлэх үйлчилгээ, арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдийн ажлын зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, шинэ аргазүйгээр ажиллах хэрэгцээ шаардлага гарч байна. Иймээс энэхүү шилжилтийн үйл явцад хяналт тавих, цаашид сайжруулах санал авах, түүнчлэн 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй шинэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд орон нутгийн мэргэжилтнүүдээс санал авах зорилгоор Мониторингийн ажлыг 21 аймгийг төлөөлөх 6 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн төслийн багтай хамтран ажиллаж эхлээд байна.</p>			√	
32.	<p>Монгол Улсын Засгийн газар болон Европын Холбоо хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр (ACA/2019/42187)-ийн хэрэгжилтийг үнэлэх Европын холбооны зөвлөх багтай хамтран ажиллав. Санхүүжилтийн хэлэлцээрээр ХНХЯ нь энэ оноос нийт 2 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ханган ажиллаж байгаа бөгөөд шалгуур үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангаж байгаа болно.</p>			√	
33.	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ашиглагдаж буй цахим системүүдийг цаашид хэрхэн сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн анхны хурал 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хуралдлаа. Ажлын хэсгийн хурлаар хөдөлмөрийн салбарт ашиглагдаж буй цахим системүүдийг танилцуулж, цаашид хэрхэн үр ашгийг сайжруулах талаар хэлэлцэв.</p>			√	
34.	<p>Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1 дүгээр улирал, 2022 оны 05 сарын байдлаар гаргаж, www.mlsp.mn сайтад байршуулав.</p>			√	
35.	<p>ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангаас жил бүр зохион байгуулдаг чуулга уулзалтад ХНХ-ын сайд А.Ариунзаяа “Монгол Улс дахь мэргэшсэн боловсон хүчний хомсдол болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх тоон мэдээлэл” сэдвээр илтгэл тавив.</p>			√	
36.	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хөдөлмөрийн маргаан зохицуулалтын талаар сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг сургалтад 6 аймгийн төвийн сум, нийслэлийн 9 дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны төрийн байгууллага, ажил олгогч болон ажилтны төлөөлөл 40 гаруй хүн оролцлоо.</p>			√	

	Сургалтыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мэргэжилтэн, олон улсын зөвлөх болон дотоодын зөвлөхүүд удирдан явууллаа.				
37.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах чиглэлээр 6 анимэйшныг бэлтгэв.			√	
38.	"Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж санал авахаар яамдад хүргүүлэв.			√	
39.	"Журам батлах тухай" Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
40.	Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх тооцоо, судалгааг хийж, Монгол Улсын 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн хязгаарт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэв.			√	
41.	"Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрыг онооны аргаар үнэлэх аргачлал"-ын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Төрийн албаны зөвлөлийн дарга нарын хамтарсан тушаалаар батлахаар тушаалын төсөл боловсруулав.			√	
42.	НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 76 дугаар чуулганаар баталсан A/RES/ 76/139 тоот "Олон улсын гэр бүлийн жилийн 30 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэх тухай" тогтоолын дагуу Монгол Улсын НҮБ-д хүргүүлэх Олон улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлд чиглэсэн бодлогын хэрэгжилтийн тайланг гаргаж, орчуулав.			√	
43.	Төрийн нарийн бичгийн даргын 2022.05.20-ны өдрийн А/104, А/105 дугаар тушаалын дагуу орон нутаг, нийслэлийн эмэгтэйчүүдийг чадавхижуулах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлаар хэлэлцүүлгийг 5-р сарын 23-наас 6-р сарын 10-ны хугацаанд зохион байгуулж, хэлэлцүүлэгт 21 аймаг, 9 дүүргийн нийт 3000 гаруй эмэгтэйчүүд хамрагдав. Ажлыг "Хувь хүний хөгжлийн алсын хараа институт" ТББ, "Импакт медиа групп" ХХК- иар тус тус гүйцэтгэсэн.			√	
44.	ЗГХА-ГБХЗХГ-г тус яамны газрын бүрэлдэхүүн очиж ажиллан, гэр бүлийн талаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцаж, холбогдох зөвлөгөө, ажлын чиглэлийг өгөв.			√	
45.	Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолоор монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны дүрмийг батлуулсан. Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооноос баталсан ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Засаг дарга нарт салбар хороог байгуулж, удирдлага зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиглэлийг хүргүүлэв.			√	
46.	БНСУ-ын КОИКА, НҮБХХ-тэй хамтран "Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх нь" төслийн эхний санхүүжилтээр гарын авлагыг хэвлүүлж, Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх танхимын болон зайн цахим сургалтыг аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүдээр зохион байгуулахаар бэлтгэж байна.			√	
47.	Залуучуудын статистикийн маягт шинэчлэх ажлын хүрээнд Үндэсний статистикийн хорооны хариуцсан мэргэжилтэнтэй 2 удаа уулзаж, анхан шатны бүртгэлийн 1, бүртгэлийн 9, захиргааны 20 маягыг боловсруулж, ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлсэн.			√	
48.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний А/107 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, батлагдсан удирдамжийн дагуу дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд: -тус яаманд мэдээллийн технологи, статистикийн хэлтэс байгуулагдсанаас хойш хийсэн ажил, бүртгэл, статистик, мэдээллийн сангийн өнөөгийн байдал, тулгарч байгаа асуудал болон цаашид харъяа байгууллага (ХХҮЕГ, ХБХХЕГ)-тай хэрхэн ажиллах талаар санал солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. -Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст 2022.06.22-нд очихоор төлөвлөж байсан боловч НДШ-ийн 50 хувийн буцаан олголттой холбоотойгоор хойшлуулаад байна.			√	

	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтэд ажлын хэсгийн бүх гишүүдийн хамт 8 сард очиж, уулзахаар төлөвлөсөн. -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт Хүүхдийн статистикийн аргачлал, Залуучуудын статистикийн маягт батлуулсаны дараа очихоор төлөвлөж байна.				
49.	Хүүхдийн статистикийн аргачлалын шинэчлэл төслийг эцэслэн боловсруулж, ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлэв.			√	
50.	Нийгмийн даатгалын салбарын статистик мэдээллээр 111 постер боловсруулсан.				
51.	Нийгмийн даатгалын албан ёсны сарын мэдээний маягтад өөрчлөлт оруулж, нэгдсэн нэг статистик мэдээлэл гаргах зорилгоор ҮСХ, НДЕГ, СЯ, ХНХЯ-ны хамтарсан уулзалт хийж, маягыг шинэчлэхээр тохиров.			√	
52.	АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ын хүрээнд төслийн нэгжтэй хамтран Өрхийн мэдээллийн сангийн системийг хөгжүүлэх 3 зөвлөх, Бизнесийн ухаалаг системийг хөгжүүлэх 2 зөвлөхийн гэрээний хэлэлцээрийг хийв.			√	
53.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд Бичвэрийг авианд хөрвүүлэх системийг хөгжүүлж буй Болорсофт ХХК болон Чимэгэ түншлэл уулзалт зохион хийх төслийн явцтай танилцаж төслийг цаашид хугацаанд нь гүйцэтгэж дуусгахад шаардлагатай зөвлөмж, санал өгөв.			√	
54.	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрт төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага болон их дээд сургуулийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мөшгөх судалгааны систем www.edu-track.gov.mn -ийн нээлтийг хийхэд шаардлагатай бэлтгэл ажил болон удирдлага зохион байгуулалтаар хангаж нээлтийг Боловсрол шинжлэх, ухааны яамтай хамтран хийв.			√	
55.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төсөл хэрэгжихтэй холбоотойгоор АХБ-нд төслийн талаарх мэдээллийг бэлтгэн хүргүүлж, холбогдох уулзалтуудыг хийв.			√	
56.	-“Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний шинэ загвар”-ыг туршин нэвтрүүлэх ажлыг Сонгинохайрхан дүүргийн “Ачлалт хүүхдүүд” ТББ, Дархан-Уул аймгийн “Ахмадын хөгжлийн төв”, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг тус тус түшиглэн хэрэгжүүлж байна. Дээрх 3 байршилд санхүү, хүний нөөц, үйлчилгээний чанарыг хөгжүүлэх, дэмжих стратегиудыг хэлэлцүүлж, шинэ стратегийн чиглэлийг хамтран тодорхойлох зорилго бүхий сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. -"Идэвхтэй насжилтыг дэмжих төв"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтыг АХБ-ны төслийн багтай хамтран Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төвд 06 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулав.			√	
57.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус үндэсний зөвлөлийн ажиллах журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас ирүүлсэн саналыг нэгтгэв. -АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд боловсруулсан Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэх программын талаарх танилцуулгын бэлтгэл ажлыг хангав. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг таниулах, туршлага солилцох хэлэлцүүлэг зохион байгуулав. -"Try Mongolia-2022" арга хэмжээнд оролцож, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. -Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааг зохицуулах удирдамжийг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлд танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.			√	
58.	“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсролын үйлчилгээний хүртээмж, дэмжлэгийн чанарыг сайжруулах, анхан шатны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгооны асуудлыг хэлэлцэх зорилготой уулзалт-хэлэлцүүлэг Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд хамтран зохион байгуулж төсөл хэрэгжиж буй II сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тусгай бүлгийн үйл ажиллагаатай танилцав. Мөн Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын хурлын үйл явцтай танилцаж, мэргэжил арга зүйн			√	

	зөвлөгөө дэмжлэг үзүүлэв.				
59.	-Төрийн үйлчилгээг сул харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх нь” салбар дундын уулзалт хэлэлцүүлгий зохион байгуулав. -Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах эрх- тэгш боломж ” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав. -“Ээлтэй ертөнц” ТББ –тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй асран хамгаалагчдад зориулсан цогц сургалт”-ыг зохион байгуулав.			√	
60.	ХНХ-ын судалгааны иниститутын нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектортой хамтран тэгш хамруулах боловсролд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үүрэг, оролцоо, уялдаа, холбоо сэдвээр судалгаа шинжилгээний ажил хийхээр хэлэлцэв.				

----- оОо -----